



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 111

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авч,
бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 198 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийслэлийн өмчөөс шилжүүлсэн 11 нэрийн нийт 2,266,640,875.00 (хоёр тэрбум хоёр зуун жаран зургаан сая зургаан зуун дөчин мянга найман зуун далан таван) төгрөгийн балансын үнэ, 1,125,177,136.51 (нэг тэрбум нэг зуун хорин таван сая нэг зуун далан долоон мянга нэг зуун гучин зургаан төгрөг тавин нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, Сангийн яаманд эзэмшүүлж, бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

2.Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга М.Баяраа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Барилгын доорх газар эзэмших эрхийг хөрөнгө хүлээн авч буй Сангийн яамны нэр дээр шилжүүлэн авах, үнэлж данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

132001299

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн
11 дугаар тогтоолын хавсралт



Төрийн өмчид хүлээн авч, Сангийн яаманд эзэмшүүлж,
бүртгэлд тусгах барилга байгууламжийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Анхны өртөг	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Поликлиник 1-гадна дулаан	1968	12,167,000	12,167,000	-
2	Поликлиник 1-Амбулатори	1987	1,777,054,984	770,372,198.33	1,006,682,785.67
3	Поликлиник 1-гадна бохир ус	1960	19,523,380	11,734,637.78	7,788,742.22
4	Поликлиник 1-гадна цахилгаан	1961	3,500,000	2,167,394.60	1,332,605.40
5	Поликлиник 1-гадна цэвэр ус	1985	4,751,440	2,544,246.26	2,207,193.74
6	Ариутгалын тасаг, микробиологийн лабораторийн засвар поликлиник-1	2020	177,639,165	54,186,753.54	123,452,411.46
	Поликлиник 1-ийн барилга байгууламжийн дүн		1,994,635,969	853,172,230.51	1,141,463,738.49
7	Поликлиник 2-Амбулатори	1960	251,526,906	251,526,906	-
8	Поликлиник 2-гадна бохир ус	1940	3,198,000	3,198,000	-
9	Поликлиник 2-гадна дулааны	2008	11,304,000	11,304,000	-
10	Поликлиник 2-гадна цахилгаан	1987	4,320,000	4,320,000	-
11	Поликлиник 2-гадна цэвэр ус	2009	1,656,000	1,656,000	-
	Поликлиник 2-ийн барилга байгууламжийн дүн		272,004,906	272,004,906	-
	НИЙТ ДҮН		2,266,640,875.00 (хоёр тэрбум хоёр зуун жаран зургаан сая зургаан зуун дөчин мянга найман зуун далан таван)	1,125,177,136.51 (нэг тэрбум нэг зуун хорин таван сая нэг зуун далан долоон мянга нэг зуун гучин зургаан төгрөг тавин нэгэн мөнгө)	1,141,463,738.49 (нэг тэрбум нэг зуун дөчин нэгэн сая дөрвөн зуун жаран хоёр мянга долоон зуун гучин найман төгрөг дөчин есөн мөнгө)